



# **ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

## АГУУЛГА

**Нэг. Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч тайлан**

### **Хоёр. Хавсралтууд:**

1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн биелэлт/ 17 хуудас/
2. ЗТХЯ-ны ил тод байдлын үнэлгээний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан / 6 хуудас/
3. Шилэн дансний хөтлөлтийн үнэлгээний тайлан / 3 хуудас/
4. Зам, тээврийн салбарын 2021 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, статистик мэдээлэл / 26 хуудас/
5. Байгууллагын шударга байдлын үнэлгээ / АТГ-аас үнэлгээг хийдэг/

### **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн журмын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тайлангуудын жагсаалт:**

1. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021.09.21-ний өдрийн 03/3801 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газар /хуучин нэрээр/-т хүргүүлсэн/,
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.01.20-ны өдрийн 01/267 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
3. 2021 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.01.28-ны өдрийн 01/225 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн/
4. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.01.20-ны өдрийн 01/267 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн/
5. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.02.28-ны өдрийн 01/909 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
6. Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.02.28-ны өдрийн 01/908 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /2022.01.20-ны өдрийн 01/266 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/
8. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.02.18-ны өдрийн 01/715 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/
9. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /2022.01.05-ны өдрийн 10/30 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн/
10. ЗТХЯ-ны 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөөний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2022.01.31-ний өдрийн 01/435 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/

### **Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дотооддоо байнгын хяналт тавин ажилласан тайлангуудын жагсаалт:**

1. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
2. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт
4. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт
5. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт



## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

2022.02.25

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид яам гэх/-ны 2021 оны үйл хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгов.

### Хоёр. Танилцуулга:

Тайлант хугацаанд яамны 2021 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, зам, тээврийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, СЗХ-наас гарсан шийдвэр, аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичиг, гэрээ, Ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримт, төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврууд зэрэг 19 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 104 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр ЗГХЭГ, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газруудад тайлагнаж ажилласан. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

### 2.1. Яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилт:

Яамны 2021 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 174 арга хэмжээний 101 нь хэрэгжсэн, 15 нь 90 хувийн хэрэгжилттэй, 22 нь 70 хувийн хэрэгжилттэй, 11 нь 50 хувийн хэрэгжилттэй, 6 нь 30 хувийн хэрэгжилттэй, үнэлгээнд оруулж тооцоогүй 9 арга хэмжээний хэрэгжилт **87.7** хувьтай байна. Яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хувиар үзүүлбэл:

№	Нэгжийн нэр	Үнэлгээ /хувиар/		
---	-------------	------------------	--	--



		Нийт арга хэмжээ	100	90	70	50	30	0	Үнэлгээнд оруулаагүй	Үнэлгээ /хувиар/
1	БТГ	<b>31</b>	24	3	2	1	-	-	1	95.3
2	АЗБХЗГ	<b>39</b>	19	2	5	1	2	-	2	85.8
3	АТБХЗГ	<b>23</b>	8	4	8	1	1	-	1	81.8
4	ТЗДТБХЗГ	<b>18</b>	7	1	3	4	1	-	1	78.0
5	ИНБХЗГ	<b>30</b>	11	5	3	4	2	-	4	75.6
6	ТЗУГ	<b>23</b>	22	-	1	-	-	-	-	98.7
7	ХШУДАГ	<b>10</b>	10	-	-	-	-	-	-	100.0
Нийт		<b>174</b>	101	15	22	11	6	-	9	87.7

Төлөвлөгөөнд үнэлгээнд тооцоогүй 9 арга хэмжээ нь өөрсдөөс хамааралгүй хэрэгжүүлэх боломжгүй болсон ба санхүүжилтгүй 5, барилгын ажил зогссон, шүүхийн маргаантай, гүйцэтгэгчтэй гэрээ цуцалсан, агаарын зам тогтоох хүсэлт ирээгүй зэрэг тус бүр 1 арга хэмжээ байна. Мөн барилгын ажлын гүйцэтгэлийн хувийг томъёогоор бодож үнэлсэн 96, 85, 82, 68, 64.7, 21.5 хувийн хэрэгжилттэй тус бүр 1 арга хэмжээ, 88, 80 хувийн хэрэгжилттэй тус бүр 2 арга хэмжээ буюу нийт 10 арга хэмжээ байна. Эдгээр томъёогоор тооцож, үнэлсэн арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

№	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/							
			96	88	85	82	80	68	64.7	21.5
1	АЗБХЗГ	<b>8</b>	-	2	1	1	2	1	1	-
2	ТЗДТБХЗГ	<b>1</b>	1	-	-	-	-	-	-	-
3	ИНБХЗГ	<b>1</b>	-	-	-	-	-	-	-	1
Нийт		<b>10</b>	-	-	-	-	-	-	-	-

Хэрэгжилт хангалтгүй 30%-тай байгаа 6 арга хэмжээ:

- 1.9.4-р арга хэмжээ: “Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замын аюулгүй байдлыг сайжруулах засварын ажлыг гүйцэтгэнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал/;
- 1.10.2-р арга хэмжээ: “Авто замын сангийн эх үүсвэр, төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэх, 2022 онд хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх” /АЗБХЗГ, 2-4 улирал/;
- 1.13.2-р арга хэмжээ: “Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэн 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх” /ИНБХЗГ, 3-4 улирал/;
- 1.15.5-р арга хэмжээ: “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн шалгалтын нэгдсэн төвийг байгуулах” /АТБХЗГ, 2-4 улирал/;
- 1.19.1-р арга хэмжээ: ““Богдхан төмөр зам” төслийн ТЭЗҮ, судалгаа, зураг төслийг хэрэгжүүлнэ” /ТЗДТБХЗГ, 1-4 улирал/;
- 1.22.11-р арга хэмжээ: “Буянт-Ухаа нисэх онгоцны буудлыг агаарын хөлгийн засварын төв болгон хөгжүүлнэ” /ИНБХЗГ, 1-4 улирал/;

ЗТХЯ-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамтаар 2022.01.31-ний өдрийн 01/435 тоот албан бчигээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

## 2.2. МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн



сайдын хариуцан хэрэгжүүлэх 96 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020-2021 онд хэрэгжүүлэх 56 арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ. Хэрэгжилт дунджаар **75.4** хувьтай байна.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг яамны газар, хэлтэс, байгууллагын хариуцсан асуудал тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

	Газар, байгууллага	Арга хэмжээ	100	90	70	50	30	0	97	84.8	67	60	42	34	Хувь
1	ТЗДТБХЗГ	10	3	1	3	2	-		1						79.7
2	"Тавантолгой төмөр зам" ХХК	1	1												100
3	"Зүүнбаян төмөр зам" ХХК	1							1						97
4	"УБТЗ" ХНН	3	1			1			1						82.3
5	"МТЗ" ТӨХК	4		1	2				1						81.7
6	ГТХЗНТ	1				1									50
7	АЗБХЗГ	24	14	1	3			1		1	1	2	1		83.9
8	"ЗТХТ" ТӨҮГ	17	12	1	2					1	1				93.04
9	АТБХЗГ	5	1		2	2									68
10	"АТҮТ" ТӨҮГ	4	1		1	2									67.5
11	ИНБХЗГ	15	4		2	3	4	1						1	56.3
12	ИНЕГ	14	3		2	3	4	1						1	53.1
13	БТГ	6	2		4										80
14	ТЗУГ	1	1												100
	<b>Нийт</b>	<b>56</b>	<b>25</b>	<b>2</b>	<b>9</b>	<b>7</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>75.4</b>

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 30-аас доош хувийн биелэлттэй дараах 6 арга хэмжээг үр дүнгүй, 50-аас доош хувийн биелэлттэй 9 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үнэлгээ
1	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барина Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	0
2	Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засвар Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь	0
3	Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.	30
4	Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ	30
5	Увс аймгийн "Дэглий цагаан" нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	30
6	Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромд их засвар хийнэ Ховд аймгийн Булган нисэх буудлуудын аэродромын их засварын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ	30
7	Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх буудлыг зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барьж, дуусган ашиглалтад оруулна Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь	34
8	Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замыг барина. Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүргэнэ.	42
9	Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор, 100 км тутамд амрах талбай байгуулна 10 байршилд барина	50
10	"Богдхан төмөр зам" төслийн ТЭЗҮ, судалгаа, зураг төслийг гүйцэтгэнэ	50
11	Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл ТЭЗҮ, зураг төсөл	50

12	Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Орхон, Говь-Сүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал байгуулна 2 автобуудал ашиглалтад оруулна.	50
13	Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийг барьж, дуусган ашиглалтад оруулна	50
14	Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	50
15	Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийг хэрэгжүүлж дуусгана. Барилгын ажлын гүйцэтгэл 80 хувь	50

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2022.01.20-ны өдрийн 01/267 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

### 2.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх 16 арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл дунджаар **90.6 хувийн биелэлттэй**, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт **76.3 хувийн биелэлттэй**, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт **85 хувийн биелэлттэй**, Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт **84.3 хувийн биелэлттэй**, Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт **81.5 хувийн биелэлттэй** тус тус үнэлэгдлээ.

№	Арга хэмжээ	Нийт заалт	100	90	70	50	30	0	Хугацаа болгоогүй	Хувь
1	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	16	7	6	2	1	-	-	-	90.6
2	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	14	8	91.7	-	53.3 54.5 50.1	19	1	-	76.3
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт	4	5	-	2	-	-	-	-	85
4	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	30	6	4	1	3	-	-	16	84.3
5	Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	30	8	3	4	4	-	-	11	81.5

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх



нийтлэг журам”-д заасны дагуу 2022.01.18-ны өдрийн 01/225 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

#### 2.4. Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Зам, тээврийн хөгжлийн сайдын шилжин хэрэгжих 14, шинээр хэрэгжүүлэх 6 арга хэмжээг 2021 оны жилийн эцсийн байдлаар үнэллээ. Шилжин хэрэгжүүлэх арга хэмжээ 76.3%, шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ 72.7%, нийт арга хэмжээний хэрэгжилт дунджаар **75.2** хувьтай байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх төмөр замын чиглэлээр 5, авто замын чиглэлээр 15, нийт 20 арга хэмжээнээс тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 1, 60 хувиас доош хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам / Хэрэгжилт 0 хувь/
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай автозам /Хэрэгжилт 53.3 хувь/
- Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 435 км автозам /Хэрэгжилт 54.5 хувь/
- Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/ /Хэрэгжилт 50.1 хувь/
- Дархан-Алтанбулагийн автозамаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/ Хэрэгжилт 19 хувь/
- Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай автозам /Хэрэгжилт 36.9 хувь/
- Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын ажил /Хэрэгжилт 35.7 хувь/

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2022.01.18-ны өдрийн 01/225 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

#### 2.5. Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилт:

Зам, тээврийн салбарт УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлого”-ын баримт бичиг хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Харин Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” /2018-2026/-ыг хүчингүй болсонд тооцсон.

Зам, тээврийн салбарын Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2022.02.28-ны өдрийн 01/908 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

№	Үндэсний хөтөлбөрийн нэр	Батлагдсан хугацаа	Тогтоолын дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	2021 оны үнэлгээ	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
---	--------------------------	--------------------	------------------	---------------------	------------------	-----------------------------

1	“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”	2010.06.24	УИХ №32	хугацаагүй		байхгүй
2	“Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”	2018.10.24	ЗГ №321	2018-2026		

### 2.5.1: “Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлого”-ын хэрэгжилт:

УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйд өсөн нэмэгдэх тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй, найдвартай хангахад чиглэсэн үр ашигтай үндэсний төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээг өргөжүүлж, улмаар улс орны дамжин өнгөрүүлэх чадавхийг дээшлүүлэн, салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг экспортлох болон боловсруулан экспортолж улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дээшлүүлэх, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах зорилгын хүрээнд нийт 7 чиглэлийг хэрэгжүүлэхээр тусгасан.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан үйл ажиллагааг чиглэлээр нь авч үзвэл:

№	Арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	1.2. Бодлогын хүрээнд шийдвэрлэх	7
2.	2.1. Төмөр замын суурь бүтцийг өргөжүүлэх, шинээр барих чиглэл болон уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулж экспортод гаргах асуудлуудыг харилцан уялдаатай шийдвэрлэх	11
3.	3.1. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ өргөжүүлэх	33
4.	4.1.1. Төмөр замын царигийн сонголт нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомжид нийцэх	6
5.	5.1.Төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх	3
6.	6.1.1. Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлого, зохицуулалтаар хангах	7
7.	7.1.Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн	6
НИЙТ		73

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхээр нийт 73 арга хэмжээнээс 2021 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй 45, 90%-ийн биелэлттэй 5, 70%-ийн биелэлттэй 5, 50%-ийн биелэлттэй 2, 30%-ийн биелэлттэй 14, 0 үнэлгээтэй буюу хэрэгжээгүй 2 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **79.7** хувьтай байна. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг ангилан үнэлбэл:

№	Бүлгүүд	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Нийт хувь
			100	90	70	50	30	0	
1	Нэг. Нийтлэг үндэслэл	7	6	-	1	-	-	-	95.7
2	Хоёр. Төмөр замын тээвэр, ашигт малтмалын орд	11	5	1	-	-	5	-	67.3



3	Гурав. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ	33	19	4	2	1	5	2	78.8
4	Дөрөв. Төмөр замын шугамын цариг	6	3	-	1	-	2	-	71.7
5	Тав. Төмөр замын тээврийн салбарын эрх зүйн зохицуулалт	3	3	-	-	-	-	-	100.0
6	Зургаа. Бодлогын хэрэгжилт, санхүүжилтийн эх үүсвэр	7	5	-	-	1	1	-	82.8
7	Долоо. Бодлогын хэрэгжилтийн үр дүн	6	4	-	1	-	1	-	83.3
БҮГД		73	45	5	5	2	14	2	79.7

### 2.5.2. “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”-ын хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого” /2018-2026/-ыг хүчингүй болсонд тооцсон бөгөөд энэхүү тогтоолын 2 дахь заалтаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, мөн "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай" Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 55 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу хүчингүй болсонд тооцсон бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр, салбарын бусад баримт бичигт уялдуулан тусгах замаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилготой.

“Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд бодлогын 8 чиглэлийн хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг чиглэлээр нь авч үзвэл:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Мэргэжил, ур чадварт тулгуурласан орчин үеийн хүний нөөцийн менежменттэй хослуулсан өрсөлдөх чадвар бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр	10
2.	Чанартай, хүртээмжтэй, хосолсон тээврийн дэд бүтцийг бий болгох замаар олон улсын тээврийг хөгжүүлэх чиглэлээр	16
3.	Тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	27
4.	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын эрэлтэд тулгуурласан, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнс, өргөн хэрэглээний барааны дотоодын тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр	17
5.	Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	21
6.	Тээвэрлэлтийн болон авто замын сүлжээний аюулгүй байдлын цогц менежментийг хөгжүүлэх чиглэлээр	20
7.	Техник, технологийн дэвшилд суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	10
8.	Автотээврийн салбарын хөгжлийг судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэн тодорхойлж, автотээврийн салбарын инновацийг хөгжүүлэх чиглэлээр	7
НИЙТ		<b>128</b>

Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 128 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн хэрэгжилттэй 24, 90%-ийн хэрэгжилттэй 9, 70%-ийн хэрэгжилттэй 30, 50%-ийн хэрэгжилттэй 14, 30%-ийн хэрэгжилттэй 27, 0%-тай буюу хэрэгжээгүй 15, хугацаа болоогүй 9 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **57.3** хувьтай байна.

Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилан авч үзвэл:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар							Нийт хувь
			100	90	70	50	30	0	ХБ	
1	Мэргэжил, ур чадварт тулгуурласан орчин үеийн хүний нөөцийн менежменттэй хослуулсан өрсөлдөх чадвар бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр	10	2	2	3	1	2	-	-	70.0
2	Чанартай, хүртээмжтэй, хосолсон тээврийн дэд бүтцийг бий болгох замаар олон улсын тээврийг хөгжүүлэх чиглэлээр	16	3	-	3	3	2	3	2	51.4
3	Тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	27	2	7	6	2	8	2	-	54.9
4	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын эрэлтэд тулгуурласан, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнс, өргөн хэрэглээний барааны дотоодын тээврийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр	17	1	-	2	-	1	8	5	22.5
5	Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	21	5	-	7	-	7	1	1	60.0
6	Тээвэрлэлтийн болон авто замын сүлжээний аюулгүй байдлын цогц менежментийг хөгжүүлэх чиглэлээр	20	3	-	4	5	7	1	-	54.7
7	Техник, технологийн дэвшилд суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр	10	3	-	3	3	-	-	1	73.3
8	Автотээврийн салбарын хөгжлийг судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэн тодорхойлж, автотээврийн салбарын инновацийг хөгжүүлэх чиглэлээр	7	5	-	2	-	-	-	-	91.4
<b>Нийт</b>		<b>128</b>	<b>24</b>	<b>9</b>	<b>30</b>	<b>14</b>	<b>27</b>	<b>15</b>	<b>9</b>	<b>57.3</b>

## 2.6. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт:

Зам, тээврийн салбарт 2021 оны байдлаар Засгийн газрын 2018 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”, Засгийн Газрын 2019 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/”, Засгийн газрын 2020 оны өдрийн 171 дугаар тогтоолоор батлагдсан “Тээврийн ухаалаг ситемийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжиж байсан ба Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор эдгээр үндэсний хөтөлбөрүүд хүчингүй болсон.

Харин Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т Чикагогийн конвенцийн Хавсралт 17 “Аюулгүй байдал” -д орсон 17 дахь удаагийн нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Журам батлах тухай” 136 дугаар тогтоол, Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-т Чикагогийн конвенцын Хавсралт 9 “Хялбаршуулах”-т оруулсан 26 дахь удаагийн нэмэлт өөрчлөлтийн стандарт, зөвлөмжийг тусган боловсруулж, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 137 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн батлуулсан.

Хүчингүй болсон үндэсний хөтөлбөрүүдийн явцыг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримталсан.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2021 онд дараах байдлаар үнэлэгдсэн байна.

№	Үндэсний хөтөлбөрийн нэр	Батлагдсан хугацаа	Тогтоолын дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	2021 оны үнэлгээ	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
1	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр	2018.05.02	ЗГ №120	2018-2022	77.6	76.3
2	Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр	2019.07.03	ЗГ №283	2019-2023	70.0	39.1
3	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”	2019.04.23	ЗГ №163	2019-2023	58.3	2.9
4	“Тээврийн ухаалаг ситемийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”	2020.05.13	ЗГ №171	2020-2024	45.4	-

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 170 дугаар тушаал, “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 309 дүгээр тушаалаар баталсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Ерөнхий сайдаар ахлуулан зохион байгуулж, “Төлөвлөгөө, журам, зөвлөмж, загвар батлах тухай” Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоолоор Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2022.02.28-ны өдрийн 01/909 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

### 2.6.1. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр” нь Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд хөтөлбөрийг 2018-2022 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 170 дугаар тушаалаар баталсан.

Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд хүчингүй болж байгаа 94 бодлогын баримт бичгийн жагсаалтад “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр” орж, тус хөтөлбөр хүчингүй болсон.

“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан 51 заалтын хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 29, 90%-ийн хэрэгжилттэй 2, 70%-ийн хэрэгжилттэй 5, 50%-ийн хэрэгжилттэй 7, 30%-ийн хэрэгжилттэй 6, 0%-ийн хэрэгжилттэй 2 заалттай, хэрэгжилтийн дундаж 77,6% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн.

Хөтөлбөрт 2018-2022 онд нийт 7 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Зорилт 1. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх – 80,5%
- Зорилт 2. Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх – 72,2%
- Зорилт 3. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын зайн зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах – 80%
- Зорилт 4. Ерөнхий зориулалтын нисэхийн салбарын боловсон хүчин бэлтгэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх - 65%
- Зорилт 5. Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээний төв байгуулах болон засвар үйлчилгээний сүлжээг бүрдүүлэх – 70%
- Зорилт 6. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээг бүрдүүлэх – 66.7%
- Зорилт 7. Иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглахыг дэмжин хөгжүүлэх - 98%

№	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
			2018	2022		
1.	Гадаад, дотоодын болон хувийн хөрөнгө оруулалт	сая. төг	1,025.0	10,000.0	13,635.0	140,5%
2.	Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нисэгч	тоо	31	100	126	137,7%
3.	Бага оврын агаарын хөлөг	тоо	17	35	36	105,5%
4.	Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, онцгой	тоо	3	10	11	114.2%

	байдлын үед ашиглах хөөрч, буух зурвас, вертодром					
5.	Байнгын болон түр хөөрч, буух зурвас, вертодром, аэродром	тоо	20	116	94	77,1%
6.	Хяналтгүй агаарын зайд үйлдэх нислэг	цаг	125	800	1005	130,4%
7.	Алслагдсан сумдын чиглэлд үйлдэх нислэг	цаг	176	3500	1165	29,7%
8.	Уул уурхайн нислэг	тоо	1130	2850	1438	17,9%
9.	Бэлтгэх хүний нөөц	тоо	8	130	126	96,7%
10.	Сургалтын байгууллага	тоо	13	25	19	50%
11.	Агаарын хөлгийн засвар, үйлчилгээний төв	тоо	12	60	17	10,4%
12.	Агаарын хөлгийн шатахуун хангамжийн төв	тоо	3	30	-	0%
13.	Хувийн нисэгчийн үнэмлэх эзэмшигч	тоо	17	150	126	81,9%
Нийт						76,3%

### 2.6.2. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”

“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” нь Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 283 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд хөтөлбөрийг 2019-2023 онд 2 үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 309 дүгээр тушаалаар баталсан.

Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд хүчингүй болж байгаа 94 бодлогын баримт бичгийн жагсаалтад “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” орж, тус хөтөлбөр хүчингүй болсон.

“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан 25 заалтын хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 11, 70%-ийн хэрэгжилттэй 5, 50%-ийн хэрэгжилттэй 3, 30%-ийн хэрэгжилттэй 5, 0%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээтэй, хэрэгжилтийн дундаж 70,0%-тай “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн байна.

Хөтөлбөрт 2018-2022 онд нийт 3 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Зорилт 1. Орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох-60%
- Зорилт 2. Орон нутгийн нислэгийг үе шаттайгаар сэргээн тогтворжуулах-77,7%
- Зорилт 3. Зорилтот бүлгийн иргэд орон нутгийн нислэгээр хөнгөлөлттэй үнээр зорчих тогтолцоо бүрдүүлэх-50%

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2018 он)	Зорилтот түвшин (2023 он)	Хүрсэн түвшин (2021 он)	хувь
1.	Эрх зүйн акт	1	2	1	50%
2.	Дотоодын агаарын тээвэрлэгчид олгосон нөхөн олговрын хэмжээ (төгрөг)	431.0 сая	10.4 тэрбум	641.1 сая	2%
3.	Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээг сурталчлан таниулсан аймгийн тоо	0	10	4	40%
4.	Нислэг сэргээсэн чиглэлийн тийзний үнийн бууралтын хувь	0	50	80	200%
5.	Зорилтот бүлгийн зорчигчийн тийзний үнийн бууралтын хувь	0	80	0	0%
6.	Зорилтот бүлгийн зорчигчийн тоо	0	21840	0	0%
7.	Орон нутгийн нислэгийн чиглэлийн тоо	8	12	12	100%
8.	Тогтмол нислэгтэй орон нутгийн нисэх буудлын тоо	8	12	12	100%
9.	Орон нутгийн нислэгийн зорчигчийн тоо (уул уурхайн захиалгат нислэгийн зорчигчийн тоо хамаарахгүй)	106149	169373	18708	-138,3%
10.	Дунд оврын агаарын хөлгийн тоо	7	10	8	33,3%
11.	Агаарын хөлгийн суудал ашиглалтын хувь	50	75	61	44%
Нийт					39,1%

### 2.6.3. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг, 2 дугаар хавсралтаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг, 2019 оны 163 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/-ийг тус тус баталсан ба 2021 оны 314 дүгээр тогтоолоор энэхүү хөтөлбөрийг хүчингүй болсонд тооцсон.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд стратегийн 4 зорилтын хүрээнд 93 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг чиглэл тус бүрээр авч үзвэл:

№	Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	21
2.	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт	26
3.	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	32
4.	"Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	14
<b>НИЙТ</b>		<b>93</b>

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 93 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны жилийн эцсийн байдлаар 100% хэрэгжсэн 13, 90%-ийн хэрэгжилттэй 5, 70%-ийн хэрэгжилттэй 26, 50%-ийн хэрэгжилттэй 25, 30%-ийн хэрэгжилттэй 20, 0% буюу тасарсан 4 арга хэмжээ байгаа ба төлөвлөгөөний хэрэгжилт **58.3** хувьтай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилбал:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар						Нийт хувь
			100	90	70	50	30	0	
1	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	21	6	3	5	3	4	-	70.9
2	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт	26	4	2	11	6	3	-	66.9
3	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	32	3	-	7	8	11	3	47.5
4	"Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	14	-	-	3	8	2	1	47.8
<b>Нийт</b>		<b>93</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>26</b>	<b>25</b>	<b>20</b>	<b>4</b>	<b>58.3</b>

Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн 2021 онд хүрсэн түвшин:

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин

№		(2018 он)	2024 он	2021 он	Хэрэгжилтийн хувь	
1.	Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам, тээврийн ослын тоо	29474	15000	21768	53.2	
2.	Зам, тээврийн ослын улмаас учирсан материаллаг хохирлын хэмжээ (төгрөг)	19.2 тэрбум	10.0 тэрбум	22 тэрбум	(30.4)	
3.	Зам, тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол (10.000 хүн тутамд)	1.7	0.85	1.3	47.0	
4.	Зам, тээврийн ослын улмаас гэмтсэн хүний тоо (10.000 хүн тутамд)	56.4	28	23.8	114	
5.	Зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл (нийт тээврийн хэрэгсэлд эзлэх хувь)	46.7	65.0	34.6	(66.1)	
6.	6 хүртэл жил ашигласан автомашины тоо (нийт автомашинд эзлэх хувь)	17	30	4.0	(100)	
7.	Техник, технологийн дэвшлийг ашиглан хяналт тавих цэгийн тоо	Улаанбаатар хотод	8	320	8	0%
		Орон нутгийн замд	50	500	61	2.4%
<b>Дүн</b>		-	-	-	<b>2.9%</b>	

#### 2.6.4 “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 171 дүгээр тогтоолоор “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2020-2024/-ийг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн А/182 дугаар тушаалаар “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд стратегийн 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

№	Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Замын хөдөлгөөнийг ухаалгаар удирдах дэвшилтэт системийг нэвтрүүлэх зорилт	7
2.	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх, мэдээлэх автомат системийг хөгжүүлэх зорилт	11
3.	Цахим төлбөрийн системийг хөгжүүлэх зорилт	7
4.	Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилт	10
5.	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	14
<b>НИЙТ</b>		<b>49</b>

Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны жилийн эцсийн байдлаар 100% хэрэгжсэн 4, 90%-ийн хэрэгжилттэй 1, 70%-ийн хэрэгжилттэй 13, 50%-ийн хэрэгжилттэй 9, 30%-ийн хэрэгжилттэй 11, 0% буюу тасарсан 10, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **45.4** хувьтай байна.



Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилбал:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар							Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
1	Замын хөдөлгөөнийг ухаалгаар удирдах дэвшилтэт системийг нэвтрүүлэх зорилт	7	-	-	-	-	3	3	1	15.0
2	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх, мэдээлэх автомат системийг хөгжүүлэх зорилт	11	-	-	4	3	1	3	-	41.8
3	Цахим төлбөрийн системийг хөгжүүлэх зорилт	7	-	-	2	2	1	2	-	38.6
4	Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилт	10	3	-	2	3	2	-	-	65.0
5	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	14	1	1	5	1	4	2	-	50.7
<b>Нийт</b>		<b>49</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>13</b>	<b>9</b>	<b>11</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>45.4</b>

## 2.7. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 6 төслийн хүрээнд 8 арга хэмжээг хамруулан 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **60.1** хувийн дундаж хэрэгжилттэй байна. 2022 онд Алтанбулаг-Замын-Үүд 998 км хурдны авто замыг эхлүүлэхтэй холбогдуулан Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдлыг хангах засвар, арчлалтын ажлыг эхлүүлээгүй тул уг төслийн ажлыг үнэлгээнд оруулаагүй болно.

№	Төслийн нэр	Арга хэмжээний нэр	2021 оны үнэлгээ	Төслийн хэрэгжилт
1	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2”	Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН-4 чиглэлийн авто замын трассын дагуу баригдах 189.7 км хатуу хучилттай авто зам (Багц CW1-1, Багц CW1-2, Багц CW1-3, CW1-4 хэсгүүд)	70 хувь	78 хувь
2	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл	“Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам”	100 хувь	89 хувь

3	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил	70 хувь	62,1 хувь
		Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдлыг хангах засвар, арчлалтын ажил	-	-
		Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засвар	100 хувь	27.8 хувь
4	Монгол Улсын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн төсөл"	Улаанбаатар-Дархан чиглэлийн 202,42 км авто замын өргөтгөлийн төсөл	100 хувь	28,5 хувь
5	"Монгол Улсын төмөр замын салбарын тогтвортой хөгжлийн чадавхыг бэхжүүлэх" бодлогын зөвлөх үйлчилгээний төсөл	Зөвлөх үйлчилгээний төсөл	100 хувь	97 хувь
6	Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"	Багц-1 барилга байгууламжийн ажил, Багц-2 аэродромын ажил гүйцэтгэх	48 хувь	38 хувь
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>84.0 хувь</b>	<b>60.1 хувь</b>

Зам, тээврийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу 2022.2.18-ны өдрийн 01/715 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

## 2.8. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 11 хуулийн 17 заалт, Улсын Их Хурлын 10 тогтоолын 17 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 11 тогтоолын 23 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 зөвлөмжийн 3 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 хуралдааны 3 заалт, Засгийн газрын 28 тогтоолын 34 заалт, Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалт, Засгийн газрын хуралдааны 39 тэмдэглэлийн 84 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 5 заалт буюу нийт 110 шийдвэрийн 193 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Бүрэн хэрэгжсэн 161, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 14, хэрэгжилт хангалтгүй 30 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, хугацаа болоогүй 13 арга хэмжээний дундаж үнэлгээ 95.7 байна.

№	Шийдвэрийн төрөл	Шийдвэр		Хэрэгжилтийн үнэлгээ				Хувь
		тоо	заалт	Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатанд 70%	Хэрэгжилт хангалтгүй 30%	Хугацаа болоогүй	
1	Монгол Улсын хууль	11	17	14	-	-	3	100.0
2	Улсын Их Хурлын тогтоол	10	17	15	1	-	1	98.1

3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	10	23	19	3	-	1	95.9
4	Ерөнхийлөгчийн зарлиг	3	4	4	-	-	-	100.0
5	ҮАБЗ-ийн зөвлөмж	3	3	2	1	-	-	90.0
6	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	1	3	1	1	-	1	85.0
7	Ерөнхий сайдын захирамж	3	3	3	-	-	-	100.0
8	Засгийн газрын тогтоол	28	34	28	1	1	4	96.6
9	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	39	84	70	7	4	3	88.7
10	Засгийн газрын албан даалгавар	2	5	5	-	-	-	100.0
Нийт		110	193	161	14	5	13	95.7

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ-үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2022.01.20-ны өдрийн 01/266 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

## 2.9. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2015-2021 оны нийт 231 тушаалын 432 заалтын хэрэгжилтийг хяналтад авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь үзүүлвэл:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Биелэлт хувь
			100	70	30	хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй	Хугацаа болоогүй		
1	Дэд сайд	10	7	1	-	-	1	1	96.25
2	ТНБД	32	20	6	-	-	6	-	93.08
3	БТГ	43	24	10	1	1	7	-	86.94
4	ТЗУГ	18	14	1	-	-	3	-	98.00
5	ХШУДАГ	89	61	13	1	1	13	-	92.63
6	АЗБХЗГ	57	39	7	1	-	10	-	94.04
7	АТБХЗГ	47	32	10	1	-	4	-	91.40
8	ТЗДТБХЗГ	40	30	7	-	-	3	-	94.32
9	ИНБХЗГ	31	24	6	-	-	1	-	94.00
10	ИНЕГ	127	78	23	3	-	23	-	91.35
11	ЗТХТ	53	32	14	1	-	6	-	89.57
12	АТҮТ	89	47	23	9	-	10	-	83.29
13	ГТХЗНТ	46	35	4	1	-	6	-	95.25
14	МИАТ	43	34	6	-	-	3	-	95.50
15	УБТЗ	47	39	2	-	-	5	1	98.54
16	МТЗ	43	31	7	1	-	4	-	92.82
17	Далайн захиргаа	49	35	5	-	-	9	-	96.25
18	НТОЗШША	9	4	2	-	-	3	-	90.00
19	төслийн нэгж	2	2	-	-	-	-	-	100.00

20	БТЕГ	-	-	-	-	-	-	-	-
21	ХХНОБ	20	17	1	-	-	2	-	98.33
НИЙТ		833	561	140	19	2	110	1	92.06
		432	282	68	10	2	61	9	91.88

Сайдын тушаалын хэрэгжилтийн байдалд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 282, 70%-ийн хэрэгжилттэй 68, 30%-ийн хэрэгжилттэй 10, тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 2, хугацаа болоогүй 61, болсон хүчингүй болсон 9 үүрэг даалгаврын хэрэгжилт **91.88** хувьтай байна.

## 2.10. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

2021 оны жилийн эцсийн байдлаар Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 1, 2017 оны 2, 2020-2021 оны 102 нийт 105 тушаалын 115 заалтын хэрэгжилтийг хяналтад авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь үзүүлвэл:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлт хувь
			100	70	30	хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй			
1	БТГ	17	13	3	-	-	1	-	94.4
2	ТЗУГ	8	5	1	-	-	2	-	95.0
3	ХШУДАГ	31	24	3	-	-	4	-	96.7
4	АЗБХЗГ	44	38	2	1	-	1	2	96.8
5	АТБХЗГ	1	1	-	-	-	-	-	100.0
6	ТЗДТБХЗГ	19	19	-	-	-	-	-	100.0
7	ИНБХЗГ	1	1	-	-	-	-	-	100.0
8	ИНЕГ	3	3	-	-	-	-	-	100.0
9	ЗТХТ	1	1	-	-	-	-	-	100.0
10	АТҮТ	-	-	-	-	-	-	-	-
11	ГТХЗНТ	-	-	-	-	-	-	-	-
12	МИАТ	-	-	-	-	-	-	-	-
13	УБТЗ	1	1	-	-	-	-	-	100.0
14	МТЗ	-	-	-	-	-	-	-	-
15	Далайн захиргаа	-	-	-	-	-	-	-	-
16	НТОЗШША	-	-	-	-	-	-	-	-
17	төслийн нэгж	-	-	-	-	-	-	-	-
18	Нийслэлийн тээврийн газар	-	-	-	-	-	-	-	-
19	Нийслэлийн авто замын хөгжлийн газар	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ		126	106	9	1	-	8	2	97.1
НИЙТ		115	98	9	1	-	7	-	96.9

Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтийн байдалд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100%-ийн хэрэгжилттэй 98, 70%-ийн хэрэгжилттэй 9, 30%-ийн хэрэгжилттэй 1, хугацаа болоогүй 7 үүрэг даалгаврын хэрэгжилт **96.9** хувьтай байна.

## 2.11. Засгийн газрын хуралдаанаар 2021 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

2021 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх 28 асуудлыг төлөвлөсөн ба хэлэлцүүлсэн 20, 70 хувийн 3, 30 хувийн 3, хэлэлцүүлэх хугацаа хойшилсон 2 асуудал, эдгээрийн дундаж хэрэгжилт **88.5** хувь байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хэлэлцэх шаардлагагүй	Биелэлт хувь
			100	70	30	0		
1	БТГ	3	2	-	1	-	-	76.6
2	ТЗДТБХЗГ	7	6	-	-	-	1	100.0
3	АТБХЗГ	6	2	1	2	-	1	66.0
4	АЗБХЗГ	2	2	-	-	-	-	100.0
5	ИНБХЗХ	10	8	2	-	-	-	94.0
<b>Нийт</b>		<b>28</b>	<b>20</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>88.5</b>

Засгийн газрын хуралдаанд 2021 онд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 28 асуудлыг Бодлого, төлөвлөлтийн газар бусад бодлогын хэрэгжилтийн газруудтай хамтран хэрэгжүүлж ажиллалаа. Үнэлэх боломжгүй арга хэмжээнд “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах /баруун гар талдаа жолооны хүрдтэй, насжилт өндөр, осолд орсон тээврийн хэрэгсэлийг үе шаттай хориглох/, “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам” зэрэг 2 арга хэмжээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй, хугацааг хойшлуулсан байна.

## 2.12. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2021 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөгөөр 28 асуудал төлөвлөсөн ба цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлтээр 10 асуудлыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар зөвлөлийн хуралдаанаар нийт 38 арга хэмжээг хэлэлцүүлсэн ба эдгээрийн хэрэгжилт 100 хувь байна.

2021 онд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний дагуу асуудал хэлэлцүүлсэн нэгж, харьяа байгууллагын үнэлгээг хүснэгтээр үзүүлвэл:

№	Нэгж, байгууллага	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Хэлэлцүүлэх шаардлагагүй болсон	Биелэлт /хувиар/
			100	70	30	0		
1	БТГ	10	10	-	-	-	-	100.0%
2	ТЗУГ	3	3	-	-	-	-	100.0%
3	АЗБХЗГ	5	5	-	-	-	-	100.0%
4	АТБХЗГ	2	1	-	-	-	1	100.0%
5	ТЗДТБХЗГ	2	2	-	-	-	-	100.0%
6	ИНБХЗГ	7	7	-	-	-	-	100.0%
7	ХШУДАГ	12	12	-	-	-	-	100.0%
8	ИНЕГ	3	3	-	-	-	-	100.0%
9	НТОЗШША	1	1	-	-	-	-	100.0%
10	“МТЗ” ТӨХК	1	1	-	-	-	-	100.0%
11	“ЗТХТ” ТӨҮГ	2	2	-	-	-	-	100.0%
<b>Нийт</b>		<b>48</b>	<b>47</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>100.0%</b>

Сайдын зөвлөлөөр 2021 оны 12 дугаар сард АТБХЗГ-аас “Хүнсний түргэн муудах бүтээгдэхүүний олон улсын тээвэрлэлт ба тээвэрлэлтэд зориулагдсан тусгай зориулалтын

тээврийн хэрэгслийн тухай хэлэлцээр, АТР-т нэгдэх чиглэлээр ажиллах тухай” асуудлыг хэлэлцүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан нь удирдлагын зүгээс хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзсэн байна.

### 2.13. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт:

2021 оны жилийн эцсийн байдлаар Сайдын зөвлөлийн хуралдааны 34 шийдвэрийн хэрэгжилтээс бүрэн хэрэгжсэн 15, 70 хувийн хэрэгжилттэй 13, 30 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээний дундаж үнэлгээ **76.1** хувь байна. Эдгээр шийдвэрийн хэрэгжилтийн байдлыг он тус бүрээр харьцуулбал:

№	Хугацаа, /оноор/	Шийдвэрийн тоо, хэмжээ	Үүнээс					Биелэлт /хувиар/
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	2019	2	-	1	1	-	-	<b>50.0</b>
2	2020	5	3	1	1	-	-	<b>80.0</b>
3	2021	27	12	11	4	-	-	<b>77.4</b>
<b>Нийт</b>		<b>34</b>	<b>15</b>	<b>13</b>	<b>6</b>			<b>76.1</b>

Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан 34 шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 30 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээг дурдвал:

1. 2019.06.03-ны өдрийн №16 “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв байгуулах тухай”;
2. 2020.10.19-ний №22 “Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх судалгааны төслийн талаар”;
3. 2021.06.30-ны өдрийн №21 “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулга”;
4. 2021.07.28-ны өдрийн №24 “Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалган тодруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн тайлангийн талаарх танилцуулга”;
5. 2021.07.28-ны өдрийн №26 “Зам, тээврийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулах ажлын явц, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, хийж хэрэгжүүлэх ажлын талаарх танилцуулга”;
6. 2021.09.30-ны өдрийн №29 “Авто замын төлбөр авах цэг цахимжуулах ажлын явцын талаарх танилцуулга”.

Сайдын зөвлөлийн хуралдааны 34 шийдвэрээр өгсөн 88 заалтын 173 үүрэг даалгаврыг 20 газар, хэлтэс болон харьяа байгууллагад хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Эдгээр 88 заалтын хэрэгжилт 100 хувийн биелэлттэй 43, 70 хувийн биелэлттэй 30, 30 хувийн биелэлттэй 15 арга хэмжээний хэрэгжилт **77.8** хувь байна. Харин газар болон харьяа байгууллагуудад өгөгдсөн 173 үүрэг даалгаврын хэрэгжилт **80.6** хувийн байна. Эдгэрийн үнэлгээг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Хариуцсан газар	Үүрэг даалгаврын тоо	Үнэлгээ /хувиар/				Биелэлтийн /хувь/
			100	70	30	0	
1	Дэд сайд	2	-	2	-	-	70.0
2	ТНБД	9	4	4	1	-	78.9

3	БТГ	29	9	15	4	1	71.4
4	ТЗУГ	4	4	-	-	-	100.0
5	АЗБХЗГ	14	8	3	3	-	78.6
6	АТБХЗГ	11	7	3	1	-	85.4
7	ТЗДТБХЗГ	8	5	3	-	-	88.7
8	ИНБХЗГ	27	16	9	2	-	84.8
9	ХШҮДАГ	15	12	2	1	-	91.3
10	ИНЕГ	26	19	5	2	-	88.8
11	МИАТ	1	-	1	-	-	70.0
12	НТОЗШША	4	2	1	1	-	75.0
13	АТҮТ	4	1	3	-	-	77.5
14	ЗТХТ	6	2	1	3	-	60.0
15	МТЗ	4	-	2	2	-	50.0
16	ГТХЗНТ	3	-	-	3	-	30.0
17	ДЗ	3	2	1	-	-	90.0
18	УБТЗ	1	1	-	-	-	100.0
19	ТТТЗ	1	1	-	-	-	100.0
20	ЗБТЗ	1	1	-	-	-	100.0
<b>Нийт</b>		<b>173</b>	<b>94</b>	<b>55</b>	<b>23</b>	<b>1</b>	<b>80.6</b>

#### 2.14. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авилгаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох, хангах талаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас хийж буй ажлын явцад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ.

Яамны үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн нээлттэй, ил тод байдлыг хангах 14 шалгуур үзүүлэлтийн биелэлт 2021 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй байна. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дүнг хүснэгтээр үзүүлэв.

№	Арга хэмжээ	Нийт заалтын тоо	Биелэлтийн хувь				Үнэлгээ /хувиар/
			100%	70%	30%	0%	
1	Үйл ажиллагааны ил тод байдал	9	9	-	-	-	100%
2	Хүний нөөцийн нээлттэй ил тод байдал	5	5	-	-	-	100%
<b>Нийт</b>		<b>14</b>	<b>14</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100%</b>

2021 оны жилийн эцсийн байдлаар ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг зам, тээврийн салбарын хэмжээнд үнэлсэн үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр үзүүлэв.

№	Газар,	Нийт заалтын тоо	Биелэлтийн хувь				Үнэлгээ /хувиар/
			100%	70%	30%	0%	
1	ТЗУГ	10	9	1	-	-	97.0
2	БТГ	4	-	3	1	-	60.0



3	АЗБХЗГ	7	2	3	2	-	67.1
4	АТБХЗГ	7	7	-	-	-	100.0
5	ТЗДТБХЗГ	5	3	2	-	-	88.0
6	ИНБХЗГ	5	2	3	-	-	82.0
7	ХШУДАГ	3	3	-	-	-	100.0
8	ИНЕГ	13	7	6	-	-	86.1
9	НТОЗШША	10	6	4	-	-	88.0
10	ДЗ	11	7	3	1	-	85.4
11	ГТХЗНТ	13	11	2	-	-	95.5
12	“АТҮТ” ТӨҮГ	13	3	10	-	-	76.9
13	“ЗТХТ” ТӨҮГ	11	2	8	1	-	71.8
14	“МТЗ” ТӨХК	12	7	3	2	-	80.8
15	“УБТЗ” ХНН	10	8	2	-	-	94.0
16	МИАТ	9	8	1	-	-	96.7
Газар тус бүрээр		143	85	51	7	-	85.9
14 үзүүлэлт		14	14	-	-	-	100.0

2021 оны жилийн эцсийн байдлаар Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт хавсаргав. /Хавсралт 2/

### 2.15. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг 2021 онд шинэчлэн байгуулсан бөгөөд санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 5 зорилтын 39 арга хэмжээ тусгагдан, 2021 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 10, 90 хувийн биелэлттэй 5, 70 хувийн биелэлттэй 6, 50 хувийн биелэлттэй 3, 30 хувийн биелэлттэй 9 арга хэмжээ болон төлөвлөгөөнд хэрэгжүүлэх хугацаа болоогүй 6 арга хэмжээний дундаж үнэлгээ 69.4 хувь байна.

“Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт тус бүрээр хүснэгтээр үзүүлэв.

№	Зорилт	Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Дундаж үнэлгээ
			100	90	70	50	30	0		
1	1-р зорилт	17	5	2	3	-	3	-	4	75.4
2	2-р зорилт	9	2	2	-	1	4	-	-	83.3
3	3-р зорилт	5	1	1	1	-	1	-	1	72.5
4	4-р зорилт	5	1	-	1	1	1	-	1	62.5
5	5-р зорилт	3	1	-	1	1	-	-	-	73.3
Нийт		39	10	5	6	3	9	-	6	69.4

“Санамж бичиг”-ийн төлөвлөгөөнд 5 зорилтын 39 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар Зам, тээврийн хөгжлийн яамны 5 нэгж, харьяа 2 байгууллага, Нийслэлийн харьяа 11 байгууллага хамтран ажиллаж байна. Эдгээр нэгж, байгууллагуудын хариуцсан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээг доорх хүснэгтээр үзүүлбэл:

№	Хэрэгжүүлэх нэгж, байгууллага	Нийт	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Үнэлгээ
			100	90	70	50	30	0		





1	БТГ	12	4	2	1	0	3	0	2	74.00
2	АЗБХЗГ	13	5	2	2	0	2	0	2	80.00
3	АТБХЗГ	12	2	3	4	0	3	0	0	70.00
4	ТЗДТБХЗГ	3	2	0	0	0	0	0	1	100.00
5	ХШУДАГ	1	1	0	0	0	0	0	0	100.00
6	АТҮТ ТӨҮГ	4	2	0	0	1	1	0	0	70.00
7	ЗТХТ ТӨҮГ	2	0	0	0	0	2	0	0	30.00
8	НАЗХГ	14	4	4	3	0	1	0	2	83.33
9	НЗХТЗИГ	9	1	1	2	0	2	0	3	65.00
10	НЗДТГ	8	1	0	2	0	5	0	0	48.75
11	НМХГ	6	1	1	2	0	2	0	0	65.00
12	ТЦА	5	1	1	2	0	1	0	0	72.00
13	УБЗАА	1	0	0	0	1	0	0	0	50.00
14	ШУЗТ	1	0	0	1	0	0	0	0	70.00
15	НТҮГ	10	2	1	2	1	4	0	0	60.00
16	НХБХГ	3	0	0	2	0	0	0	1	70.00
17	ЗХУТ	5	1	1	1	0	2	0	0	64.00
18	НГЗБА	1	0	0	1	0	0	0	0	70.00
Нийт		110	27	16	25	3	28	0	11	69.49

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах санамж бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2021 оны 02 сарын 28-ны өдрийн 01/910 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

### 2.16. Зам, тээврийн хөгжлийн сайд болон аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2021 оны хамтын ажиллагааны гэрээний зорилго нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн чиглэлээр тусгагдсан бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлж, орон нутгийн зам, тээврийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, хүн амын амьдралын таатай нөхцлийг хангах, иргэдийн ая тухтай зорчих боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн ба 21 аймгийн Засаг дарга нартай авто зам, автотээвэр, агаарын тээвэр, төмөр зам, усан замын тээврийн чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2021 оны хамтын ажиллагааны гэрээнд нийт 743 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн биелэлттэй буюу бүрэн хэрэгжсэн 321, 90 хувийн биелэлттэй 110, 70 хувийн биелэлттэй буюу үр дүн гарсан 67, 50 хувийн биелэлттэй 7, 30 хувийн биелэлттэй 92, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 40, гэрээгээр төлөвлөсөн боловч үнэлгээнд тооцох боломжгүй 106 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **88.14%**-тай байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг аймаг тус бүрээр авч үзвэл:

№	Аймаг	Нийт	Үнэлгээ /хувиар/						Үнэлгээнд тооцоогүй арга хэмжээ	ХШҮ
			100	90	70	50	30	0		
1	Архангай	36	9	3	4	0	14	2	4	58.44
2	Баян-Өлгий	38	17	8	4	0	6	0	3	82.29

3	Баянхонгор	27	12	2	5	0	5	0	3	78.33
4	Булган	35	8	3	3	0	13	4	4	53.87
5	Говь-Алтай	32	12	8	5	0	1	1	5	85.19
6	Говьсүмбэр	34	12	5	5	0	1	0	11	88.26
7	Дархан	36	20	7	2	0	1	1	5	90.32
8	Дорноговь	36	14	6	3	0	0	2	11	86.00
9	Дорнод	47	18	10	5	3	5	0	6	81.71
10	Дундговь	29	12	7	1	0	3	2	4	79.60
11	Завхан	28	8	4	1	0	8	3	4	61.25
12	Орхон	31	17	2	0	1	4	0	7	85.42
13	Өвөрхангай	29	16	4	4	0	0	1	4	89.60
14	Өмнөговь	36	22	8	0	0	1	2	3	89.39
15	Сүхбаатар	40	13	3	3	1	2	3	15	75.60
16	Сэлэнгэ	44	17	4	5	0	8	7	3	64.63
17	Төв	35	23	3	1	0	0	5	3	82.50
18	Увс	36	24	3	0	0	5	1	3	85.45
19	Ховд	40	13	8	7	0	6	3	3	72.70
20	Хөвсгөл	38	21	7	4	0	3	1	2	86.11
21	Хэнтий	36	13	5	5	2	6	2	3	72.12
<b>Нийт</b>		<b>743</b>	<b>321</b>	<b>110</b>	<b>67</b>	<b>7</b>	<b>92</b>	<b>40</b>	<b>106</b>	<b>88.14</b>

Зам, тээврийн хөгжлийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2021 оны хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг 2021 оны гэрээний биелэлттэй харьцуулахад 14.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт 2021 оны 02 сарын 28-ны өдрийн 01/910 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

### **2.17. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлангийн хэрэгжилт:**

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрийн 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмыг үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулга, стандартын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас аудит хийж ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яам шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээ оруулахаас 145 мэдээ оруулж, тайлагнах хугацаандаа 137 мэдээ, хугацаа хоцроож тайлагнасан 8 мэдээлэлийг байршуулсан байна. 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт **97.32** хувийн биелэлттэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 92 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2021 оны 4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийв.

- Улсын төсвийн байгууллага 4
- Төсөл, арга хэмжээ 13

- Төрийн өмчит үйлдвэрийн газар 51
- Төрийн өмчит хувьцаат компани 21
- Хувь нийлүүлсэн нийгэмлэг 1
- Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани 1
- Төрийн өмчит ХХК 1 гэсэн нийт 92 төрийн байгууллага, хуулийн этгээд байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг хангахад хяналт тавьж ажиллахаас гадна Зам, тээврийн хөгжлийн сайдын “Хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай” 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/79 тоот тушаал, Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудитын хорооны 2021 оны 01 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайланг хуулийн хугацаанд Зам, тээврийн хөгжлийн салбарын 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт **84.34** хувийн биелэлттэй.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг, 2021 оны жилийн эцсийн байдлаар 2022.1.5-ны өдрийн 10/30 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Шилэн дансны хэрэгжилтийн тайланг хүргүүлэв. /Хавсралт 3/

### **2.18 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:**

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 28 арга хэмжээг 2021 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 20, 90 хувийн хэрэгжилттэй 4, 70 хувийн хэрэгжилттэй 1, 50 хувийн хэрэгжилттэй 1, үнэлгээнд тооцоогүй 2 арга хэмжээний хэрэгжилт **95.6** хувь байна.

Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлвэл:

№	Зорилтын дугаар	Арга хэмжээний тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
1	1	5	10	100.0
2	2	3	4	65.0
3	3	2	2	95.0
4	4	8	11	88.8
5	5	3	10	97.5
6	6	4	5	97.5
7	7	3	5	100.0
Нийт		28	47	95.6

Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд цар тахлын улмаас хойшлогдсон 17-р арга хэмжээ болох “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар шинэ санал, санаачилгыг дэмжиж ажиллана”, 18-р арга хэмжээ болох “Ахмад төрийн албан хаагчдын сургамж, зөвлөгөөг залуучуудад хүргэх, тэднээс суралцах, шинэ залуу боловсон хүчнийг төлөвшүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна” 2 арга хэмжээг үнэлгээнд оруулж тооцоогүй байна.

Хөтөлбөрийн биелэлтэд “Албан хаагчдыг зуслангийн газар өмчилж авахад нь туслалцаа үзүүлэх, зуслангийн байр барихад нь байгууллагын зүгээс санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэлбэрийг эрэлхийлнэ” 7-р арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, “Төрийн албан хаагчийг амьдрах орчин нөхцлөө сайжруулах, орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.” 8-р арга хэмжээний хэрэгжилт 50 хувь байна.

2021 оны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 5 албан хаагчийг түрээсийн орон сууцад хамруулсан байна. Мөн яамны боло харьяа байгууллагын ажилчдын барилгын ажлыг эхлүүлсэн нь сайшаалтай байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсаргав. /Хавсралт 1/

## 2.19. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Зам, тээврийн хөгжлийн яамны Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 16 үзүүлэлтийн 35 заалтын 11 үзүүлэлт нь 100% болон түүнээс дээш хувиар биелж, зорилтот түвшиндээ 1 үзүүлэлт хүрээгүй байна.

Зорилтот түвшингээс илүү гарсан үзүүлэлтүүдийг 100% гэж дүгнэвэл Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт дунджаар **82.9** хувийн биелэлттэй байна. Энэ нь 2020 оноос 0.9 хувиар буурсан байна.

№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Суурь үзүүлэлт /2020 он/	2021 он		
				Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Хувь
1	Тээвэрлэсэн ачаа (мян.тонн)	Автотээвэр	30454.9	22768.45	17970.30	78.9
		Төмөр замын тээвэр	30001.2	30384.3	31193.20	102.7
		Агаарын тээвэр	2.74	2.48	6.43	259.3
2	Дамжин өнгөрөх (транзит) ачаа (мян.тонн)	Төмөр замын тээвэр	4278.1	4111.5	4239.60	103.1
3	Ачаа эргэлт (сая тонн/ км)	Автотээвэр	4685.3	3460.2	2313.92	66.9
		Төмөр замын тээвэр	19167.6	18534.7	18390.40	99.2
		Агаарын тээвэр (мян.тонн/км)	8100	8.87	11.93	134.5
4	Зорчигчдын тоо (мян.хүн)	Автотээвэр	124 100	118700.0	106530	89.7
		Төмөр замын тээвэр	1965.75	2092.9	360	17.2
		Усан замын тээвэр	31.1	32.1	20	62.3
		Агаарын тээвэр	447.5	491.2	200	40.7
5	Зорчигч эргэлт (сая хүн/ км)	Автотээвэр	2178	1895.8	1023	54.0
		Төмөр замын тээвэр	579.3	613.75	95.65	15.6
		Агаарын тээвэр	659.57	707.4	449.37	63.5
6	Тээвэрлэлтийн орлого (тэрбум төгрөг)	Автотээвэр	564.38	506.4	413.90	81.7
		Төмөр замын тээвэр	775.9	782.4	771.20	98.6
		Агаарын тээвэр	164.1	154.9	200.06	129.2
7	Зам, тээврийн салбарт шинээр нэвтрүүлсэн техник, технологийн тоо	Зам, тээвэр	8	3	3	100.0
8	Нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон	Авто зам	17	21	21	100.0

	аймгийн төвийн тоо					
9	Олон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний урт (өссөн дүнгээр) (км)	Авто зам	7441	7841	7502.7	95.7
10	Шинээр ашиглалтад оруулах замын урт (км)	Авто зам	2117.3	126.6	90.7	71.6
		Төмөр зам /гол/	1949.4	681.6	0	0.0
11	Шинээр ашиглалтад орсон гүүрийн урт (м)	Авто зам	1984.75	300.6	1181.5	393.0
12	Тээврийн чиглэлийн тоо	Автотээвэр	247	71	63	25.5
		Олон улсын нислэг	34	35	30	85.7
13	Буулт, хөөрөлтийн тоо (мян.)	Агаарын тээвэр	7.284	7.7	7.1	92.2
14	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо (мян.)	Агаарын тээвэр	71.4	70.9	68.71	96.9
15	Тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт	Автобус	163	530	106	20.0
		Зүтгүүр	163	160	174	108.8
		Ачааны вагон	6049	6595	6506	98.7
		Зорчигчийн вагон	344	270	228	84.4
		Агаарын хөлөг	36	36	25	69.4
16	Вокзал буудлын тоо (өссөн дүнгээр)	Автовокзал	25	26	25	96.2
		Төмөр замын буудлын тоо	79	71	79	111.3
		Нисэх буудлын тоо	25	25	25	100.0

Зам, тээврийн салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй статистик мэдээллийн хамт хавсаргав. /Хавсралт 4/

## ГУРАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. Тайлант хугацаанд яамны 2021 оны үйл ажиллагааг яам, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, зам, тээврийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, СЗХ-наас гарсан шийдвэр, аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичиг, гэрээ, Ил тод байдал, Шилэн дансны хөтөлөлт зэрэг 19 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 104 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан байна.

2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас



нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр ЗГХЭГ, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан.

3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны үйл ажиллагааг дүгнэвэл:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	95.7	0.6	2,58
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	75.4		
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	90.6		
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	82.9		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	87.7	0.2	0,91
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	95.6		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100.0	0.2	0,98
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	97.3		
	3. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
<b>ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ</b>			<b>1.0</b>	<b>4.48</b>

Шударга байдлын үнэлгээг АТГ-аас гаргадаг, 2021 оны Хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар хийхээр шийдвэрлэсэн.

Ерөнхий үнэлгээ хийсэн аргачлал:  

$$\sum = 0.05 * [(95.7 + 75.4 + 90.6 + 82.9) \div 4 * 0.6 + (87.7 + 95.6) \div 2 * 0.2 + (100.0 + 97.3) \div 2 * 0.2] = 0.05(51.69 + 18.33 + 19.73) = 4.48$$

### ГУРАВ. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилт удаашралтай байгаа, хэрэгжээгүй гэж үнэлэгдсэн арга хэмжээнүүдийг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр хугацаа алдалгүй авч ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагуудад;
2. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг

тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу ЗГХЭГ-аас баталж ирүүлсэн аргачлал, загварын баримтлан яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний хэрэгжүүлэх хугацааг сар, улирлаар тогтоон улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлын хүрэх түвшинг улирал тус бүрээр тодорхой төлөвлөх, нэгжүүдийн оролцоог ялгаатай тогтоохыг яамны газар, харьяа агентлаг, байгууллагуудад;

3. Бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд тэргүүлэх ач холбогдол өгч, санхүүжилтийг жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгуулж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;
4. Зам, тээврийн салбарын хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг 2022 оны эхний хагаст багтаан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын чуулганаар батлуулан эдгээр хуулиудтай уялдуулан боловсруулахаар хүлээгдэж буй хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтцийн шинэчлэл хийх ажлуудыг түргэвчлэхийг яамны холбогдох газруудад;
5. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа арга хэмжээнүүдийн талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлуудыг яаралтай дуусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;
6. Санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжих боломжтой хууль, эрх зүйн орчинг сайжруулах, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, журам, төлөвлөгөө боловсруулж батлуулах, судалгаа хийх, байнгын ажиллагаатай ажлыг хэсгүүдийг хуралдуулах зэрэг арга хэмжээнүүдийг хугацаанд нь хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан 2022 онд багтаан хэрэгжүүлэх ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагуудад;
7. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор Төрөөс баримтлах бодлогын брамт бичиг, үндэсний хөтөлбөрүүд хүчингүй болсонд тооцсон тул баримт бичиг, хөтөлбөрүүдэд тусгагдаад хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай зорилт, арга хэмжээг дунд хугацааны Хөгжлийн зорилтод хөтөлбөрт тусгах, ингэхдээ зорилт, арга хэмжээнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг зөв тооцох, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг 2023 оны Төсвийн тухай хуульд тусгах, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бодитой төлөвлөж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ.**